



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчис Ойл ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/099/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 260512 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261805 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261885 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)  
Юнистар аудит ХХК  
Захирал: М.Энхжаргал  
Утас: 11-328735 Цахим хаяг: [info@unistaraudit.mn](mailto:info@unistaraudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ЭРЧИС ОЙЛ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯНМӨНХ ТАНАА

2025.03.14 № 07/1080  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчис Ойл ТӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

-Тайлант онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинд төлөвлөснөөс борлуулалт 27,165.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь агаарын хөлгийн түлшийг зах зээлийн боломжит доод үнээр агаарын тээвэрлэгч нарт нийлүүлдгээс шалтгаалсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аялал жуулчлал сэргэж, гадаад улсууд руу нисэх нислэгийн чиглэл, давтамж нэмэгдэж буйтай холбогдуулан Засгийн газрын 2023 оны 385 дугаар тогтоолоор Эрчис ойл ХХК-д 2024 онд агаарын хөлгийн түлшний нөөцийг 179,880 тонноор нэмж бүрдүүлэх үүрэг өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

## Бусад асуудлын хэсэг

Эрчис Ойл ТӨХХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын шатахуун хангамжийн байгууламжийг нэгтгэх бэлтгэл ажлыг хангасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	1,855,572,541.91	7,750,214,687.27
1.1.2	Дансны авлага	1,021,641,715.12	4,889,316,586.33
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	247,228,959.88
1.1.4	Бусад авлага	1,190,194.36	16,500.00
1.1.6	Бараа материал	17,068,482,084.14	21,760,301,789.76
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,326,839,315.81	12,338,298,502.93
<b>1.1.20</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>28,273,725,851.34</b>	<b>46,985,377,026.17</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	41,092,531.85	51,999,946.84
1.2.2	Биет бус хөрөнгө	19,915,818.18	17,851,515.18
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>61,008,350.03</b>	<b>69,851,462.02</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,334,734,201.37</b>	<b>47,055,228,488.19</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	21,180,485.32	-
2.1.1.3	Татварын өр	1,555,657,316.89	1,355,037,199.95
2.1.1.4	НДШ-ийн өглөг	23,316.76	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	20,384,000,135.13	27,455,262,797.41
2.1.1.9	Нөөц (өр төлбөр)	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	357,069,254.78	489,406,558.56
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>22,317,930,508.88</b>	<b>29,299,706,555.92</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>22,317,930,508.88</b>	<b>29,299,706,555.92</b>
2.3	<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
	Өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	12,872,663,616.48
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	6,015,803,692.49	4,881,858,315.79
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>6,016,803,692.49</b>	<b>17,755,521,932.27</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>28,334,734,201.37</b>	<b>47,055,228,488.19</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>154,186,635,241.25</b>	<b>215,915,059,447.34</b>
2	Борлуулалтын өртөг	136,242,674,551.86	193,126,901,041.09
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>17,943,960,689.39</b>	<b>22,788,158,406.25</b>
5	Хүүний орлого	106,275,942.98	69,194,483.31
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,537,474,961.37	5,931,274,433.10
10	Ерөнхий ба удирдлагын зардал	750,159,308.16	1,700,191,734.78
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	(6,792,944,475.13)	(6,059,051,438.29)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>6,969,657,887.71</b>	<b>9,166,835,283.39</b>
19	Орлогын татварын зардал	1,730,729,354.98	1,746,418,232.58
20	Татварын дараах ашиг (алдагдал)	5,238,928,532.73	7,420,417,050.81
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>5,238,928,532.73</b>	<b>7,420,417,050.81</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Бусад олз (гарз)	-	5,934,898,161.17
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>5,238,928,532.73</b>	<b>1,485,518,889.64</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,000,000.00</b>	-	<b>776,875,159.75</b>	<b>777,875,159.75</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	-	776,875,159.75	777,875,159.75
Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	5,238,928,532.74	5,238,928,532.74
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,000,000.00</b>	-	<b>6,015,803,692.49</b>	<b>6,016,803,692.49</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,619,464,266.34)	(2,619,464,266.34)
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	-	3,396,339,426.15	3,397,339,426.15
Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	1,485,518,889.64	1,485,518,889.64
Бусад дэлгэрэнгүй орлого	-	12,872,663,616.48	-	12,872,663,616.48
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,000,000.00</b>	<b>12,872,663,616.48</b>	<b>4,881,858,315.79</b>	<b>17,755,521,932.27</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	171,259,844,664.05	238,319,738,222.80
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	171,256,289,664.05	238,319,618,962.80
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	119,260.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,555,000.00	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	168,035,908,700.36	230,161,706,625.68
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	440,457,521.00	1,886,224,338.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	120,384,899.12	265,246,019.96
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	73,730,179,612.90	197,786,265,537.47
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	352,878,439.72
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	13,034,223,440.87	22,734,313,349.88
1.2.9	Бусад мөнгөн зарлага	80,710,663,226.47	7,136,778,940.65
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,223,935,963.69</b>	<b>8,158,031,597.12</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>106,732,929.19</b>	<b>76,836,365.97</b>
2.1.5	Хүлээн авсан хүүний орлого	106,732,929.19	76,836,365.97
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>40,681,200.00</b>	<b>27,222,400.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,021,200.00	25,242,400.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,660,000.00	1,980,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>66,051,729.19</b>	<b>49,613,965.97</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	45,223,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	45,223,000,000.00
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	45,223,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	45,223,000,000.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
4	<b>Гадаад валютын ханшийн зөрүү</b>	<b>(3,288,289,761.64)</b>	<b>(2,313,003,417.73)</b>
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,697,931.24</b>	<b>5,894,642,145.36</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,853,874,610.67</b>	<b>1,855,572,541.91</b>
7	<b>Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,855,572,541.91</b>	<b>7,750,214,687.27</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт-, хэмнэлт+	Хувь
<b>1</b>	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>243,149,965.8</b>	<b>215,984,253.9</b>	<b>27,165,711.9</b>	<b>88.8</b>
1.1	Үүнээс: Борлуула лтын орлого	м.төг	243,149,965.8	215,915,059.4	27,234,906.4	88.8
1.2	Бусад орлого		-	69,194.5	(69,194.5)	-
<b>2</b>	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>243,139,438.6</b>	<b>206,817,418.6</b>	<b>36,322,020.0</b>	<b>85.1</b>
2.1	Бараа материалын өртөг	м.төг	230,161,202.6	199,185,952.5	30,975,250.1	86.5
2.2	Ерөнхий ба удирдлагын зардал	м.төг	1,909,727.9	1,700,191.7	209,536.2	89.0
2.3	Борлуулалт, маркетингийн зардал	м.төг	11,068,508.1	5,931,274.4	5,137,233.7	53.6
<b>3</b>	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>10,527.2</b>	<b>9,166,835.3</b>	<b>(9,156,308.1)</b>	<b>877.6</b>
<b>4</b>	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>9,474.5</b>	<b>7,420,417.1</b>	<b>(7,410,942.6)</b>	<b>320.0</b>
5	Төсвийн төлбөрт	м.төг	24,833,869.3	20,761,224.1	4,072,645.3	83.6
5.1	Үүнээс: НДШ 24-26%	м.төг	303,529.4	265,246.0	38,283.4	87.4
5.2	ХХОАТ 10%	м.төг	240,710.8	102,641.6	138,069.2	42.6
5.3	ААНБОАТ 10%	м.төг	1,052.7	1,551,651.9	(1,550,599.2)	934.5
5.4	НӨАТ 10%	м.төг	24,288,576.4	18,841,684.6	5,446,891.8	77.6
6	Нийт ажиллагсдын тоо	хүн	20	20	-	100.0
7	Нийт цалингийн сан	м.төг	1,270,146.0	1,155,981.5	114,164.5	91.0
8	Нэг ажилтны дундаж цалин	м.төг	2,942.4	3,627.0	(684.6)	123.3
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	м.төг	1.00	0.97	0.0	97.3
10	Хөрөнгө оруулалт	м.төг	47,250.0	24,747.6	22,502.4	52.4
11	Нийт авлага	м.төг	5,301,564.9	17,474,860.5	(12,173,295.7)	329.6
12	Нийт өглөг	м.төг	6,576,165.6	29,299,706.6	(22,723,540.9)	445.5
13	Ашигт ажиллагааны түвшин	м.төг	0.00	0.03	(0.27)	881.7

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нийт 4,373.4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа илэрснээс аудитын явцад алдааг залруулсан.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д/д	Алдааны товч утга	/сая төгрөгөөр/							
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Урьдчилж төлсөн тооцооны үлдэгдлийг нийт 55.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	55.1	-	-	1	55.1	1	55.1
2	Байгууллагын болзошгүй өр төлбөрөөс хамгаалах худалдан авалтын нөөц сангийн 4,318.3 сая төгрөгийг борлуулалт марктенгийн зардлаар бүртгэснийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт залруулсан.	1	4,318.3	-	-	1	4,318.3	1	4,318.3
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>4,373.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>4,373.4</b>	<b>2</b>	<b>4,373.4</b>

**3.2** 4000.16-  
хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын  
хэрэгтэй

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 1

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн цахим системд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>